

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээ /2021 оны 1 дүгээр улирлын байдлаар/

Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх агентлаг, төсөвт байгууллагад 2021 оны 1 дүгээр улиралд иргэдээс нийт 4554 өргөдөл, гомдол, санал ирүүлсэн байна. Үүнээс өргөдөл 4326 буюу 94.9 хувь, гомдол 181 буюу 4.0 хувь, санал 47 буюу 1.0 хувийг тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд нийт 4554 өргөдөл, гомдол, санал ирсэний 4285 буюу 94.0 хувь нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдэж, 468 буюу 10.2 хувь нь бусад байгууллагад шилжүүлж, 269 буюу 5.9 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй байна.

Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах төв”-д нийт 6 иргэн хандсанаас төрийн албан хаагчийн томилгоо, ёс зүйтэй холбоотой 3, отор, нүүдэлтэй холбоотой 1, газрын эзэмшилтэй холбоотой 1, нийт 5 гомдол, 1 талархал ирүүлсэн байна. Ирүүлсэн 4 гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 1 гомдлыг холбогдох байгууллагад шилжүүлэн шийдвэрлэх шатандаа байна.

Аймгийн Засаг даргын 2018 оны а/676 дугаар захирамжаар баталсан “Аймгийн Засаг даргаас нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлэх журам”-ын дагуу 2021 оны 1 дүгээр улиралд аймгийн Засаг даргад хандаж мөнгөн тусламж хүсч өргөдөл ирүүлсэн 20 иргэнд 6.6 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүллээ.

Аймгийн онцгой комиссын тусгай дугаарын 7032-2855 утсанд давхардсан тоогоор нийт 4642 иргэн хандаж коронавируст халдвар /ковид-19/-тай холбогдон гарсан шийдвэр, түүнтэй холбоотой мэдээллийг аваад байна. Мөн *Өвөрхангай-“Ковид-19” нэгдсэн мэдээлэл-цахим* хуудсаар дамжуулан коронавируст халдварын талаарх иргэдийн тавьсан санал, хүсэлтэд тодорхой мэдээлэл өгөн ажиллаж байна.

Коронавируст халдвар /ковид-19/-ын нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан иргэдийн өргөдөл, гомдол, саналыг аймгийн “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн 7032-1111 дугаарын нээлттэй утас, аймаг, сум, агентлагуудын цахим хуудсаар хүлээн авч шийдвэрлэн ажиллаж байна.

Хуралдааны тэмдэглэлийг хавсаргав.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

СУМЫН ЗАСАГ ДАРГА, АГЕНТЛАГИЙН ДАРГА НАРТ

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хурлын 7 дугаар тэмдэглэлд:

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурал цахимаар хуралдаж 2021 оны 1 дүгээр улирлын “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт”-ийн мэдээг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Н.Энхцэцэг гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан сумын Засаг дарга, агентлагийн дарга нарт даалгав.

1. 2021 оны 1 дүгээр улирлын өргөдөл, гомдлын тайлан, мэдээг хугацаанд нь ирүүлээгүй байгууллагын албан тушаалтанд хариуцлага тооцон, дараагийн улирлын өргөдөл, гомдлын мэдээнд тусган танилцуулах.

2. Төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд улирал бүр дүн шинжилгээ хийж, асуудлын мөн чанарыг судалж, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч ажиллах.

3. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд хуулийн хугацаанд хариу өгч, шийдвэрлэлтийг байгууллага болон иргэдэд ил тод мэдээлэх.

4. Улирал, хагас, бүтэн жилийн тайлан, мэдээг тухайн сум, агентлагийн дарга нарын гарын үсэгтэй албажуулж, танилцуулгын хамт аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх гэжээ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2021.03.31

Арвайхээр

| д/д | Байгууллагын нэр | Нийт өргөдөл, гомдлын тоо | Шийдвэрлэлт | | | | Шийдвэрлэлт /Хувь/ |
|-----|---|---------------------------|------------------------|-------------------------------|------------------|------------------|--------------------|
| | | | Шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хугацаа хэтэрсэн | Хугацаа болоогүй | |
| 1. | Аймгийн ЗДТГазар | 96 | 81 | 35 | 0 | 15 | 84.3 |
| 2. | Агентлагууд | 259 | 222 | 0 | 4 | 37 | 85.7 |
| 3. | Сумд | 4067 | 3855 | 301 | 4 | 212 | 94.7 |
| 4. | Аймгийн Үйлчилгээний нэгдсэн төв /70321111/ | 132 | 127 | 132 | 0 | 5 | 96.2 |
| Дүн | | 4554 | 4285 | 468 | 8 | 269 | 94.1 |

--oOo--

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ /ХЭЛБЭРЭЭР/

2021.03.31

Арвайхээр

| д/д | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт | Үүнээс: | | | | |
|------------|---|---|-------------|------------|------------|-----------|----------|
| | | | Бичгээр | Цахимаар | Утсаар | Биечлэн | Бусад |
| 1. | Аймгийн ЗДТГазар | 96 | 96 | - | - | - | - |
| 2. | Агентлагууд | 259 | 245 | - | 13 | 1 | - |
| 3. | Сумд | 4067 | 3667 | 217 | 115 | 68 | - |
| 4. | Аймгийн Үйлчилгээний нэгдсэн төв /70321111/ | 132 | 5 | - | 127 | - | - |
| Дүн | | 4554 | 4013 | 217 | 255 | 69 | - |
| Хувь | | 100% | 88.1% | 4.7% | 5.5% | 1.5% | - |

--oOo--

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН АГУУЛГА /ХУВИАР/

2021.03.31

Арвайхээр

| Аймгийн нэр | /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/ | | | |
|---|---|--------|------|-------|
| Өвөрхангай аймаг | Нийт өргөдөл, гомдол, санал 4554 ирсэн байна. | хүсэлт | 4326 | 94.9% |
| | | гомдол | 181 | 4.0% |
| | | санал | 47 | 1.0% |
| | Нийгмийн халамжийн үйлчилгээ | | 1109 | 24.3% |
| | Иргэний бүртгэл, мэдээлэл | | 587 | 12.8% |
| | Газар эзэмших, өмчлөх, шилжүүлэх | | 436 | 9.5% |
| | Ажилд орох, чөлөөлүүлэх | | 372 | 8.1% |
| | Тэтгэвэр тогтоолгох, тэтгэмж хүссэн | | 249 | 5.4% |
| | Иргэний шилжилт хөдөлгөөнтэй холбоотой | | 167 | 3.6% |
| | Хөдөлмөр эрхлэлт | | 79 | 1.7% |
| | Материал, мөнгөн тусламж хүссэн | | 57 | 1.2% |
| <p>- Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг Аймгийн “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн 70321111 дугаарын утсаар хүлээн авч байна. Өргөдөл, гомдол, санал нийт 132 ирсэнээс гомдол 114 буюу 86.3 хувь, мэдээлэл, тодруулга, санал 47 буюу 35.6 хувийг эзэлж байна. Нийт 132 өргөдөл, гомдол, санал ирснээс 127 буюу 96.2 хувь нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна.</p> | | | | |